



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 18 он 04 дугаар  
сарын 30 ны өдөр

Дугаар ХЭГ/  
1902

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ч.УЛААН, Д.ТЭРБИШДАГВА,  
Б.БАТ-ЭРДЭНЭ НАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас Оюутолгой төслийн хүрээнд байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувь нийлүүлэгчдийн гэрээ” болон “Оюутолгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-ний талаар Та бүхнээс тавьсан асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



 Г.ЗАНДАНШАТАР

004726

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ч.УЛААН, Д.ТЭРБИШДАГВА, Б.БАТ-ЭРДЭНЭ НАРААС  
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАРТ ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Монгол Улсын Засгийн газар Оюутолгой төслийн хүрээнд “Хөрөнгө оруулалтын гэрээ” болон “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-г 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр байгуулж, 2011 оны 6 дугаар сарын 8-ны өдөр уг “Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд “Нэмэлт өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ”-г байгуулсан байна.

Харин “Оюутолгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж “Эрдэнэс Монгол” ХХК болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирлууд, бусад хувьцаа эзэмшигч “Туркойс Хилл Ресурс Лимитед”, “Ти Эйч Ар Оюу Толгой ЛТД”, “Оюу Толгой Нидерланд Би Ви”, “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед”, “Оюу Толгой” ХХК-ийг төлөөлж холбогдох эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулжээ.

Монгол Улсын Засгийн газраас дээрх “Оюутолгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-тэй холбоотой дараах шийдвэрүүдийг гаргасан байна:

-Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд *“Хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж, холбогдох төлөвлөгөө, баримт бичгийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах...”*;

- Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд *“Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалт, түүний санхүүжилттэй холбоотой асуудлаар Хөрөнгө оруулагч талтай хийж байгаа хэлэлцээний явц, үр дүнг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газар болон Хувь нийлүүлэгч талыг төлөөлж Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг эцэслэн тохирох...”*

-Ерөнхий сайдын 2015 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 99 дүгээр захирамжаар *“Хөрөнгө оруулагч талтай хийсэн хэлэлцээний дүнг үндэслэн Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурах эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт олгосон”*;

-Ерөнхий сайдын 2015 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 123 дугаар захирамжаар *“Улсын Их Хурлын 2009 оны 57, 2014 оны 34, 2015 оны 41 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн асуудлаар удирдамжийн дагуу хэлэлцээ хийж, эцэслэн дуусгах. Монгол Улсын Засгийн газар буюу Хувь нийлүүлэгчийг төлөөлж Оюутолгой төслийн Далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөнд гарын үсэг зурахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт зөвшөөрсөн” байна.*

“Оюутолгойн Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө”-г 2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, түүний хавсралтаар “Менежментийн гэрээ”-г баталгаажуулсан байна.

Дээрх баримт бичиг болон Оюутолгой төслийн үйл ажиллагаатай холбоотой

тулгамдаж байгаа асуудлыг судлан шийдвэрлэх зорилгоор Ерөнхий сайд дараах захирамжуудаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна:

1.Ерөнхий сайдын 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 40 дүгээр захирамжаар Оюутолгой ордыг ашиглах төслийн хэрэгжилттэй холбогдсон зарим тулгамдсан асуудлыг зохицуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, гэрээний биелэлтэд хяналт тавих, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тусгагдсан асуудлаар холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Өмнөговь аймгийн нутгийн удирдлагын байгууллага, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн төлөөллийг оролцуулан байгуулсан. Ерөнхий сайдын уг захирамжийг үндэслэн дараах чиг үүрэг бүхий хоёр Дэд ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулсан байна:

-Оюутолгой ордыг ашиглах төсөл болон компанийн үйл ажиллагааг ашигтай явуулах, төслийн хэрэгжилтэд тулгамдаж байгаа татвартай холбоотой асуудал, ногдол ашгийг нэмэгдүүлэх боломжийг судалж, зохистой байдлаар шийдвэрлэх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан санхүүгийн Дэд ажлын хэсэг;

-Оюутолгой ордыг ашиглах төсөл болон Хөрөнгө оруулалтын гэрээ, уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ, Туслах үйлчилгээний гэрээ, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тусгагдсан зарим асуудлаар хууль зүйн тайлбар болон санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан хуулийн Дэд ажлын хэсэг тус тус байгуулан ажилласан бөгөөд холбогдох санал, дүгнэлтээ гаргаж, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.

2.Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 155 дугаар захирамжаар “Стратегийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхтэй холбоотой асуудлаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, орд ашигласнаас Монгол Улсын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, Монголын талын эрх ашгийг хамгаалах чиглэлээр дүгнэлт гаргаж, санал боловсруулах, гэрээтэй холбоотой үүсэх маргааныг Монголын талд ашигтайгаар шийдвэрлүүлэх, зарим гэрээний нөхцөлийг сайжруулах талаар зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Бодлогын зөвлөл байгуулж, уг зөвлөлийн даргаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ажиллаж байна. Энэхүү Бодлогын зөвлөл 3 удаа хуралдаж, уг төслийн тулгамдсан асуудлаар холбогдох санал, дүгнэлт гаргах дараах Ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна:

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 256 дугаар тушаалаар Оюутолгой ордыг ашиглах, төслийн хэрэгжилттэй холбогдсон зарим тулгамдсан асуудлыг зохицуулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тулгамдсан асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулсан Ажлын хэсэг;

-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 280 дугаар тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн санхүүжилтийн асуудлаар Сангийн дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсгийг тус тус байгуулсан.

Ерөнхий сайдын 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар

захирамжаар Оюутолгой төслийн хэрэгжилттэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.3(ё) заалтын дагуу санхүүжилтийн болон зээлийн хүүгийн хувийг хянан үзэж, холбогдох яриа хэлэлцээг хөрөнгө оруулагч талтай хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Энэхүү Хөрөнгө оруулагч талтай яриа хэлэлцээг хийх үүрэг бүхий Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Судалгааны багийг Бодлогын зөвлөлийн дарга бөгөөд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 71 дүгээр тушаалаар байгуулж, уг багийн ахлагчаар Сангийн яамны Төрийн бичгийн дарга ажиллаж байна.

Түүнчлэн, Ерөнхий сайдын 2018 оны 27 дугаар захирамжийн дагуу Өмнийн говийн хөгжил, дэд бүтэц, эрчим хүчний асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Эрчим хүчний яаманд дараах Дэд ажлын хэсгүүд байгуулагдаж, холбогдох чиглэлийн дагуу ажиллаж байна:

-Эрчим хүчний сайдын 2018 оны 38 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газар, "Оюу Толгой" ХХК-тай байгуулсан "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний 7.3-д заасны дагуу Оюутолгой төслийн нийт эрчим хүчний хэрэгцээг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэрээс хангах гэрээний үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах үүрэг бүхий Дэд ажлын хэсэг;

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/74 дүгээр тушаалаар Оюутолгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Өмнийн говийн хөгжил, дэд бүтцийн асуудлаар Дэд ажлын хэсэг.

Оюутолгой төслийн хүрээнд тулгамдаж байгаа асуудлыг дотооддоо шийдвэрлэх ажиллагаанд Монголын талын эрх ашгийг хамгаалахаар дээрх Бодлогын зөвлөл, Ажлын хэсгүүд нь "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн толгой компани, Төлөөлөн удирдах зөвлөл, Монголын талын Хувьцаа эзэмшигчтэй хамтран ажиллаж байна.

---ooOoo---